

GOBI

MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

**ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН 2020**

- 02-04** КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА
Бидний үнэ цэнэ
Бүтэц зохион байгуулалт
- 05-08** БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
Онцлох үйл явдлууд
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт
Шинэ коллекциуд
- 09-14** САНХҮҮГИЙН ТАЙЛАН
Санхүү, үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд
Санхүүгийн тайлан
Их хэмжээний хэлцэл
Сонирхлын зөрчилтэй хэлцэл
Санхүүжилтийн мэдээлэл
Компанийн удирдлагын зардал
- 15-16** ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА
Хувьцааны арилжаа
Ногдол ашиг
- 17-28** КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ
Засаглалын тогтолцоо
Хувьцаа эзэмшигчид
Хувьцаа эзэмшигчдийн хурал
Төлөөлөн удирдах зөвлөл
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
Эрх бүхий албан тушаалтнууд
Тогтвортой хөгжил

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Компанийн оноосон нэр	Говь Хувьцаат Компани
Үйл ажиллагааны чиглэл	Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах
Компанийн албан ёсны хаяг	Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Утас: (976)-70139977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobi.mn Вэб сайт: www.gobi.mn Фэйсбүүк: GobiCashmere
	Онлайн дэлгүүр: www.gobicashmere.com www.gobicashmere.com/uk/ www.gobicashmere.com/us/ www.gobicashmere.com/de/ www.gobicashmere.com/fr/ www.gobicashmere.com/pl/ www.gobicashmere.com/ru/ gobicashmere.world.taobao.com/
Компанийн удирдлага	ТУЗ-ийн дарга: Дамбын ГЭРЭЛМАА Гүйцэтгэх захирал: Цагаачийн БААТАРСАЙХАН
Үүсгэн байгуулагдсан огноо	1981 оны 9 сарын 5-ны өдөр
Ажилтнуудын тоо	2,054
Хүчин чадал	1,100 тонн түүхий ноолуур боловсруулах 820 тонн ээрмэл болон нарийн ээрмэл утас хийх 1,500,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 1,000,000 метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 162,000 ширхэг ноолууран пальто, пиджак үйлдвэрлэх
Дэлгүүрийн тоо	Дотоод Улаанбаатар хот 3 Дархан хот 1 Гадаад Цахим дэлгүүр 8 Салбар дэлгүүр 1 Франчайз дэлгүүр 41

БИДНИЙ ҮНЭ ЦЭНЭ

САНХҮҮГИЙН НӨӨЦ

Хувьцаа эзэмшигчид, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага болон үйл ажиллагаанаас эх үүсвэртэй шаардлагатай санхүүжилт (зээл, баталгаа...)

ХҮНИЙ НӨӨЦ

Бидний гол нөөцийн нэг болох ажилтнуудын ур чадвар, мэдлэг туршлага нь хүний нөөцийн хөгжлөөр нэмүү өртөг үүсгэх гол боломж болно

ҮЙЛДВЭРИЙН НӨӨЦ

Говь ХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ хүргүүлэхэд шаардлагатай үйлдвэрлэлийн зориулалт бүхий биет материал болон хөрөнгө

ОЮУНЫ НӨӨЦ

Бидний ирээдүйн орлогын баталгаа, өрсөлдөх хүч болсон оюуны өмч, брэнд болон нэр хүнд

БАЙГАЛИЙН НӨӨЦ

Бидний ирээдүйн сайн сайхны үр үндэс болох байгалийн нөөц баялаг (түүхий ноолуур, ус, агаар, хөрс, бүтээгдэхүүн зэргийн эрүүл байдал)

НИЙГЭМ ХАРИЛЦААНЫ НӨӨЦ

Говь ХК болон бусад бүх оролцогч талуудтай үүсэх харилцаа нь компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын баталгаа болно

БИДНИЙ ЗОРИЛТ

Говь ХК нь хүний хөгжил, технологиор тэргүүлэн, хэрэглэгч, харилцагчдын сэтгэл ханамжийг хамгийн өндөрт хүргэж, хөрөнгө оруулагч, ажилтнуудын үнэ цэнтэй байгууллага байна

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- Шударга, ил тод, нээлттэй
- Хууль дүрмийг чандлан сахиулна
- Хүний эрхийг дээдэлнэ
- Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ
- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулна

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



MONGOLIAN CASHMERE

БАТЛАВ. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


Ц.БААТАРСАЙХАН

Гүйцэтгэх захирлын 20... оны ... сарын ...
өдрийн тоот тушаалын
Хавсралт №...

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

[РС]тэмдэгтэй нь ашгийн төв

[NPC]тэмдэглэгээтэй нь ашгийн бус төв



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

4 сарын 24-ний өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг анх удаа цахим хэлбэрээр зохион байгууллаа. Хуралд нийт 690,229,999 саналын эрхтэй 84 хувьцаа эзэмшигч оролцож, хурлын ирц 88.48% байв.



ГОВЬ ХК-ИЙГ "ТОП-100" АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭГЭЭР ӨРГӨМЖИЛЛӨӨ

2020 оны 5 сарын 20-ний өдөр Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "ТОП-100" Аж Ахуйн Нэгжийг шалгаруулах ёслол болж, Говь ХК нь 19 дугаар байранд шалгарлаа.



ГОВЬ ХК ЭЛЧИН САЙДУУДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Тус арга хэмжээг 6 сарын 26-ний өдөр зохион байгуулсан бөгөөд хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор АНУ, Европ, Англи, Франц, Европын худалдааны танхим, Герман, Канад улсын элчин сайд, төлөөлөгч нарыг хүлээн авч, Говь ХК-ийн цаашдын стратеги төлөвлөгөөг танилцуулж, санал бодол солилцов.



МАРКЕТИНГИЙН АГЕНТ ЧИГЛЭЛЭЭР ДЭЛХИЙД ТЭРГҮҮЛЭГЧ "OGILVY" КОМПАНИТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Олон улсын брэндийн стратеги, дижитал маркетинг чиглэлээр тус компанитай хамтын ажиллагаа эхлүүлэн амжилттай ажиллаж байна.



ГОВЬ БРЭНД ДЭЛХИЙ ДАЯАР ХЭРЭГЛЭГЧ БҮРД УЛАМ ОЙРТЛОО

Бид олон улсын зах зээлийн цар хүрээгээ улам өргөжүүлэхэд анхааран ажиллаж байгаа бөгөөд дэлхий даяар хэрэглэгчид Говь брэндийн бүтээгдэхүүнийг худалдан авах боломж улам нээгдсээр байна. Манай онлайн дэлгүүр Англи, Герман, Орос, Хятад, Польш, Франц хэл дээр тус тус ажиллаж эхэллээ.

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН



АРАБ АЛЧУУР



БАДАМЛЯНХУА БАРЛАСАН ШААЛЬ

ШИНЭ КОЛЛЕКЦИУД

ҮНДСЭН КОЛЛЕКЦ



ГОВЬ ХАВАР/ЗУН 2020



ГОЁО ХАВАР/ЗУН 2020



YAMA ХАВАР/ЗУН 2020



ОНЛАЙН ХАВАР/ЗУН 2020

НЭМЭЛТ КОЛЛЕКЦ




МОНГОЛ ДЭЭЛЭН
ЗАГВАРТАЙ ПАЛЬТО



НААДАМ 2020



ХАТГАМАЛТАЙ ПИДЖАК



HERDERS

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2020.06.30			2019.06.30 гүйцэтгэл	Өмнөх оноос өсөлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт		тоо	хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	<i>сая.төг</i>	81,720	37,462	46%	67,702	(30,240)	-45%
Дотоод борлуулалт	<i>сая.төг</i>	49,031	18,808	38%	44,137	(25,330)	-57%
Гадаад борлуулалт	<i>сая.төг</i>	32,689	18,654	57%	23,565	(4,911)	-21%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	<i>сая.төг</i>	55,001	25,150	46%	44,508	(19,359)	-43%
НИЙТ АШИГ	<i>сая.төг</i>	26,718	12,312	46%	23,194	(10,882)	-47%
Нийт үйл ажиллагааны зардал	<i>сая.төг</i>	33,828	32,856	97%	19,658	13,198	67%
Үйл ажиллагааны бус зардал	<i>сая.төг</i>	(1,809)	(1,986)	90%	(1,121)	(864)	-77%
Татварын өмнөх ашиг	<i>сая.төг</i>	(8,919)	(22,530)	-53%	2,415	(24,945)	-1033%
ЦЭВЭР АШИГ	<i>сая.төг</i>	(8,919)	(21,397)	-40%	1,633	(23,030)	-1410%
Цэвэр ашгийн хувь	<i>хувь</i>	-11%	-57%	-323%	2%	-60%	-2468%
Экспорт	<i>мян.USD</i>	11,470	6,663	58%	8,918	(2,255)	-25%
Ерөнхий удирдлага, борлуулалт маркетингийн зардал	<i>сая.төг</i>	17,935	15,830	88%	11,735	4,095	35%
Орлогын 1 төгрөгт ногдох зардал	<i>төгрөг</i>	0.2	0.4	193%	0.2	0.2	144%
ҮЙЛДВЭРЛЭЛТ							
Сүлжмэл	<i>ширхэг</i>	492,314	490,780	100%	418,495	72,285	17%
Нэхмэл	<i>метр</i>	226,202	110,702	49%	209,706	(99,004)	-47%
Оёмол	<i>ширхэг</i>	42,736	26,511	62%	43,196	(16,685)	-39%
Ээрмэл	<i>тонн</i>	157	127	81%	147	(20)	-13%
ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛ Ноолуур	<i>тонн</i>	650	655	101%	410	245	60%
АЖИЛТНУУДЫН ТОО	<i>хүн</i>	2,069	2,054	99%	2,712	(658)	-24%
Нэг ажилтанд ногдох орлого	<i>мян.төг</i>	39,497	18,239	46%	24,964	(6,725)	-27%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	<i>сая.төг</i>	1,621	374	23%	4,176	(3,802)	-91%

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2020 оны 6 сарын 30
(мян. төг)

	2019.12.31	2020.06.30
ХӨРӨНГӨ		
<i>Эргэлтийн хөрөнгө</i>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10,641,744	3,111,036
Дансны ба бусад авлага	12,976,180	11,385,449
Урьдчилгаа төлбөр	4,215,397	3,738,030
Бараа материал	178,135,943	220,148,198
Орлогын албан татварын авлага	266,632	266,632
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө	565,290	668,413
	206,801,186	239,317,756
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>		
Үндсэн хөрөнгө	134,043,015	128,754,794
Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	2,371,039	1,821,453
Хойшлогдсон татварын хөрөнгө	2,710,343	3,845,269
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	574,327	537,303
	139,698,724	134,958,820
Нийт хөрөнгийн дүн	346,499,910	374,276,576
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
<i>Богино хугацаат өр төлбөр</i>		
Дансны ба бусад өглөг	37,803,959	34,513,230
Буцаах эрхтэй барааны өр төлбөр	913,198	1,028,327
Түрээсийн өр төлбөр	686,742	597,215
Гэрээний өр төлбөр	2,153,354	1,321,990
Богино хугацаат банкны зээл	189,267,962	105,776,358
	230,825,215	143,237,120
<i>Урт хугацаат өр төлбөр</i>		
Урт хугацаат өр төлбөр	2,085,657	5,272,488
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	1,865,656	1,436,302
Урт хугацаат банкны зээл	32,560,000	166,623,927
	36,511,313	173,332,717
Нийт өр төлбөрийн дүн	267,336,528	316,569,837
<i>Эзэмшигчдийн өмч</i>		
Хувьцаат капитал	780,113	780,113
Дахин үнэлгээний нэмэгдэл	15,647,697	15,647,697
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(278,529)	(338,208)
Хуримтлагдсан ашиг	63,014,101	41,617,137
	79,163,382	57,706,739
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	346,499,910	374,276,576

НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

2020 оны 6 сарын 30
(мян. төг)

	2019.12.31	2020.06.30
Борлуулалтын орлого	209,748,268	37,461,894
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(141,951,917)	(25,149,621)
Нийт ашиг	67,796,351	12,312,273
Санхүүгийн ба бусад орлого	711,312	286,214
Бусад олз ба (гарз)	(3,445,430)	(2,076,071)
Хүүгийн зардал	(21,811,123)	(15,391,440)
Борлуулалт ба маркетингийн зардал	(27,941,691)	(11,818,100)
Ерөнхий ба удирдлагын зардал	(10,243,248)	(5,841,814)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэний бууралт	(978,735)	(610)
Татварын өмнөх ашиг	4,087,436	(22,529,549)
Орлогын татварын зардал	(1,630,963)	1,132,583
Тайлант жилийн цэвэр ашиг	2,456,473	(21,396,965)
Дараа үеүдэд ашиг, алдагдал руу ангилагдах бусад иж бүрэн орлого:		
Гадаад дахь охин компаниас үүссэн валют хөрвүүлэлтийн зөрүү	(143,326)	(59,678)
Бусад иж бүрэн (зарлага)/орлого	(143,326)	(59,678)
Нийт иж бүрэн орлого	2,313,147	(21,456,644)

НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2020 оны 6 сарын 30
(мян. төг)

	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт
2019 оны 01 сарын 31-ний үлдэгдэл	780,113	15,647,697	(135,203)	101,361,568	117,654,175
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	2,456,473	2,456,473
Бизнесийн нэгдлийн нөлөөлөл	-	-	(143,326)	(35,499,175)	(35,642,501)
Бусад иж бүрэн орлого				-	-
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	-	(143,326)	2,456,473	2,313,147
Зарласан ногдол ашиг	-	-	-	(5,304,765)	(5,304,765)
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	15,647,697	(278,530)	63,014,101	79,163,382
Тайлант жилийн цэвэр ашиг				(21,396,965)	(21,396,965)
Бусад иж бүрэн орлого					-
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	-	(59,678)	(21,396,965)	(21,456,643)
Зарласан ногдол ашиг	-	-	-		-
2020 оны 06 сарын 30-ний үлдэгдэл	780,113	15,647,697	(338,208)	41,617,137	57,706,739

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2020 оны 6 сарын 30
(мян. төг)

	2019.12.31	2020.06.30
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	41,799,388	(54,990,624)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(34,127,136)	(1,880,720)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(2,031,447)	49,134,742
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	5,640,805	(7,736,601)
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	59,999	205,893
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,940,940	10,641,744
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,641,744	3,111,036

ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлангийн хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй.

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Доорх холбоотой талуудтай хийсэн гүйлгээнүүд нь зах зээлийн нөхцлөөр хийгдсэн болно.
(мян. төг)

ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ	2020.06.30
Холбоотой талд өгсөн санхүүжилт	12,459,400
Холбоотой талаас авсан санхүүжилт	12,459,400
Холбоотой талтай хийсэн борлуулалт	37,171
Холбоотой талаас авсан худалдан авалт	564,651
Хүүгийн орлого	-
Хүүгийн зардал	1,329,248
Түрээсийн орлого	119,795
Түрээсийн зардал	438,164

САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

(мян. төг)

БАНКНЫ НЭР	2019.12.31	2020.06.30	ЭЗЛЭХ ХУВЬ
Голомт Банк	88,424,400	32,000,000	12%
Худалдаа Хөгжлийн Банк	4,372,943	4,458,498	2%
Монгол Улсын Хөгжлийн Банк	42,900,000	82,900,000	31%
Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк	37,275,273	34,400,115	13%
Хас Банк	12,100,000	12,100,000	4%
Хаан Банк	27,730,000	4,450,000	2%
Азийн Хөгжлийн Банк	6,000,000	4,980,000	2%
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк	-	95,216,400	35%
САНХҮҮЖИЛТИЙН ДҮН	218,802,616	270,505,013	100%


КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

(мян. төг)

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2019.06.30	2020.06.30
ТУЗ-ийн цалин урамшуулал	72,000	79,200
Удирдлагын цалин урамшуулал	267,656	398,078
Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	13,665	13,921
НИЙТ	353,321	491,199

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

ҮЗҮҮЛЭЛТ	2020.06.30		2019.12.31	2019.06.30	
ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО (шир)	780,112,500		780,112,500	780,112,500	
Төрөл	энгийн хувьцаа		энгийн хувьцаа	энгийн хувьцаа	
ХУВЬЦААНЫ ҮНЭ (төг)*	Өсөлт, бууралт /%/				
	2019.12.31-нээс				2019.06.30-наас
Хаалтын үнэ	195	27.8% ↓	33.8% ↓	270	294.31
Хамгийн их үнэ	292	17.5% ↓	17.5% ↓	354.11	354.11
Хамгийн бага үнэ	165	34.5% ↓	40.2% ↓	251.98	275.79
Дундаж үнэ	217.9	25.3% ↓	29.1% ↓	291.60	307.48
АРИЛЖААЛАГДСАН ТОО (шир)	2,195,830	72% ↓	53.2% ↓	7,848,937	4,694,166
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН (мян. төг)	465,466	80.3% ↓	68.6% ↓	2,368,533	1,483,271
КОМПАНИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (мян. төг)	152,121,937	27.8% ↓	33.7% ↓	210,630,375	229,594,910

НОГДОЛ АШИГ

НОГДОЛ АШИГ ТАРААЛТЫН ТАЙЛАН

Ногдол ашиг зарласан он	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	Нийт зарласан ногдол ашгийн дүн (мян. төг)	Ногдол ашиг тараалт
1996	61	475,869	Говь ХК 2007 онд хувьчлагдсан бөгөөд түүнээс өмнөх жилүүдэд зарласан ногдол ашгийг компани дээрээ тарааж байна.
1997	154	1,199,813	
1998	150	1,170,169	
1999	166	1,294,987	
2000	100	780,113	
2001	20	157,271	
2005	60	468,068	
2006	60	468,068	
2010	100	780,113	ҮЦТХТ-өөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар 100% тараасан.
2011	100	780,113	
2012	125	975,141	
2013	130	1,014,146	
2014	140	1,092,158	
2015	140	1,092,158	
2016	200	1,560,225	
2017	220	1,716,247	
2018	6.8	5,304,765	2019 оны 4 сарын 25-ны өдрөөс тарааж эхэлсэн.
2019	-	-	ТУЗ-ийн 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 04 тоот тогтоолын дагуу 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилаагүй болно.


КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО

Говь ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо (ширхэг)	Эзэмшлийн хувь
ТАВАН БОГД ТРЕЙД ХХК	391,811,700	50.23%
ХИДЕ ИНТЕР ХХК	265,238,300	34.00%

НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

780,112,500

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТОО

17,737

/2020.06.30-ны байдлаар/

ХИДЕ ИНТЕР ХХК Хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. /Япон улс/

ТАВАН БОГД ТРЕЙД ХХК нь "Таван Богд Групп"-ийн толгой компани ба 1997 онд Группийн хэмжээнд бодлого стратегийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага юм. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр 10:00 цагт Outlet дэлгүүр дээрээс зохион байгуулагдав. Дэлхий даяар үүссэн нөхцөл байдал, COVID 19-тэй холбоотой хөл хорионы улмаас Говь ХК хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа анх удаа цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулсан бөгөөд "Gobi Cashmere" албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан шууд дамжуулалтыг хүргэсэн билээ. Хуралд 88.48 хувийн саналын эрхтэй нийт 84 хувьцаа эзэмшигчид оролцож хурлын ирц бүрдсэнээр хурал хүчин төгөлдөр явагдсан бөгөөд нийт 3 асуудлыг хэлэлцэж батлав.

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн "Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2019 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан" гэсэн дүгнэлт өгснийг 100%-ийн саналаар батлав.
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг 97.04%-ийн саналаар батлав.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг олонхын саналаар батлав.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлдэг. ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг сар тутмын тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлдгийг өгч ажиллаж байна. Мөн дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Эрсдэл аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодыг байгуулж, компанийн засаглалыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, Эрсдэл аудитын хорооны удирдлага дор Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Эрсдэл, аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдал, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Нэр дэвшүүлэх хороо

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Цалин, урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ХАРААТ БУС ГИШҮҮД



**Дамбын
ГЭРЭЛМАА**

ТУЗ-ийн дарга
Хараат бус гишүүн

/Цалин
урамшууллын
хорооны дарга, Нэр
дэвшүүлэх хорооны
гишүүн/

**СЭЗИС, Бизнес
удирдлагын
тэнхимийн
профессор**



**Мягмарын
БАЯР**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

/Нэр дэвшүүлэх
хорооны дарга/

**ШУТИС-ийн ҮТС-ийн
Хөнгөн
үйлдвэрлэлийн
технологи
инженерчлэлийн
салбарын дэд
профессор**



**Банзрагчийн
НАНДИН-ЭРДЭНЭ**

ТУЗ-ийн хараат
бус гишүүн

/Эрсдэл, аудитын
хорооны дарга/

**СЭЗИС, Бизнесийн
Удирдлагын
тэнхимийн ахлах
багш**



**Такэши
КАМБЭ**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

/Цалин урамшууллын
хорооны гишүүн/

**Asahi Life Insurance
Менежер**



**Алтангэрэлийн
ЖАРГАЛМАА**

ТУЗ-ийн хараат
бус гишүүн

/Эрсдэл, аудитын
хорооны гишүүн/

**Garе, асса ахлах
багш, хөтөлбөрийн
удирдагч**

ЕРДИЙН ГИШҮҮД



**Цагаачийн
БААТАРСАЙХАН**

ТУЗ-ийн ердийн
гишүүн

/Нэр дэвшүүлэх
хорооны гишүүн/

**Таван Богд
Группийн
Ерөнхийлөгч,
Говь ХК-ийн
Гүйцэтгэх захирал**



**Дашдаваагийн
ХУЛАН**

ТУЗ-ийн ердийн
гишүүн

/Эрсдэл, аудитын
хорооны гишүүн/

**Таван Богд
Группийн Тэргүүн
дэд ерөнхийлөгч**



**Хидэо
САВАДА**

ТУЗ-ийн ердийн
гишүүн

**Н.І.С компанийн
Ерөнхийлөгч**





**Жавзандолгорын
ОЮУНЧИМЭГ**

ТУЗ-ийн ердийн
гишүүн

/Цалин урамшууллын
хорооны гишүүн/

**Таван Богд Групп,
Маркетингийн
газрын захирал**

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД

ОВОГ НЭР АЛБАН ТУШААЛ	АЖЛЫН ТУРШЛАГА
 <p>Цагаачийн БААТАРСАЙХАН</p> <p>Гүйцэтгэх захирал</p>	<p>Алтай ХХК-д Орлогч захирал, Таван Богд Трейд ХХК, Жуулчин ХХК, МИАТ ХК-иудын Ерөнхий захирал, Палас зочид буудлын Гүйцэтгэх захирлын албан тушаалуудыг хашиж байсан.</p> <p>Таван Богд Группийн Ерөнхийлөгч, Хаан Банкны ТУЗ-ийн гишүүн, 2008 оны 8 сараас одоог хүртэл Говь ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.</p>
 <p>Отгонбаатарын БОЛОРБАТ</p> <p>Тэргүүн дэд захирал</p>	<p>Таван Богд Трейд ХХК-д Судалгааны мэргэжилтэн, Таван Богд Хүнс ХХК Гадаад харилцаа, брэнд менежер, Говь ХК Гадаад худалдаа хариуцсан захирал, Таван Богд Косметик ХХК Дэд захирал, Таван Богд Интернэйшнл ХХК Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байсан.</p> <p>2020 оноос Говь ХК-ийн Тэргүүн Дэд захирлаар томилогдон ажиллаж байна.</p>
 <p>Чулуунбатын СОЛОНГО</p> <p>Хүний нөөц, захиргаа хариуцсан захирал</p>	<p>Алтандорнод Монгол ХХК-д Гадаад харилцааны менежер, Боловсон хүчин, Таван Богд Групп-д Гадаад худалдааны менежер, Борлуулалт хариуцсан ахлах менежерээр тус тус ажиллаж байсан.</p> <p>2014 оноос одоог хүртэл Говь ХК-д Хүний нөөц, захиргаа хариуцсан захирлаар ажиллаж байна.</p>
 <p>Ганболдын СЭЛЭНГЭ</p> <p>Санхүү хариуцсан захирал</p>	<p>Гермес Тэсүн ХХК-д Ерөнхий нягтлан бодогч, Хаан Палас ХХК-д Ахлах нягтлан бодогч, Таван Богд Групп-д Нягтлан бодогч, Ерөнхий нягтлан бодогчоор тус тус ажиллаж байсан.</p> <p>2013 оноос одоог хүртэл Говь ХК-д Санхүү хариуцсан захирлаар ажиллаж байна.</p>



**Базаррагчаагийн
ӨНӨБОЛД**

Санхүү, стратеги
төлөвлөлт
хариуцсан захирал

ШУТИС Багш, Монгол Экономич ХХК Сэтгүүлч, Бодь Даатгал ХХК Бизнес хөгжлийн менежер, Говь ХК Санхүү төлөвлөлтийн хэлтсийн даргаар тус тус ажиллаж байсан.

2020 оноос Говь ХК-д Санхүү, стратеги төлөвлөлт хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Энхтөрийн
ЗОРИГТ**

Дотоод худалдаа
хариуцсан захирал

Улаанбаатар Принт ХХК Дэд захирал, Таван Богд Электроникс ХХК Гүйцэтгэх захирал, Таван Богд ХХК Гүйцэтгэх захирал, Mongolian Youth Federation Ерөнхийлөгчийн зөвлөх, X-Core ХХК Зөвлөх, Eurofarm Pharmacy Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байсан.

2020 оноос Говь ХК-д Дотоод худалдаа хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Отгонтөгсийн
МИШЭЭЛ**

Гадаад худалдаа
хариуцсан захирал

Швед улс, Берга ХХК Ерөнхий менежер, Valiant Art ХХК Худалдааны менежер, Говь ХК Гадаад худалдааны менежер, онлайн худалдааны менежерээр тус тус ажиллаж байсан.

2020 оноос Говь ХК-ийн Гадаад худалдаа хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Энхдалайгийн
МИШЭЭЛ**

Онлайн худалдаа
хариуцсан захирал
/Хятад/

БНХАУ Shanghai Fuhai E-Commerce ХХК Төслийн менежер, Reach China Group Limited компанид БНХАУ-ын салбарт Төслийн менежерээр тус тус ажиллаж байсан.

2020 оноос Говь ХК-д Онлайн худалдаа хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Батбаярын
МӨНХ-ОРГИЛ**

Онлайн худалдаа
хариуцсан захирал
/Орос/

ГХЯ Мэргэжилтэн, МҮХАҮТ Газрын дарга, Мөнх Дэвжих Буян ХХК Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байсан.

2020 оноос Говь ХК-д Онлайн худалдаа хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Даваанямын
НАНДИНБАЯР**

Онлайн худалдаа
хариуцсан захирал
/Герман/

Сайншанд Салхин парк Төслийн менежер, Евро Хан ХХК Төслийн менежерээр тус тус ажиллаж байсан.

2020 оноос Говь ХК-д Онлайн худалдаа хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Баяртогтохын
ОЮУНСҮРЭН**

Онлайн худалдаа
хариуцсан захирал
/Европ/

Туушин ХХК Нягтлан бодогч, Жени Ойл Шейл Монголиа ХХК Ерөнхий нягтлан бодогч, Говь ХК Санхүү хариуцсан менежер, нягтлан бодогчоор тус тус ажиллаж байсан.

2020 оноос Говь ХК-д Онлайн худалдаа хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Билэгтийн
ТАМИР**

Онлайн худалдаа
хариуцсан захирал
/Америк/

АПУ ХК Гадаад харилцааны албаны дарга, ТЭСО корпораци, МИЛКО ХХК Борлуулалт маркетинг хариуцсан захирал, Ард санхүүгийн нэгдэл ХК Маркетингийн захирал, Хөрөнгө оруулагч үндэстэн ХК Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байсан.

2020 оноос Говь ХК-д Онлайн худалдаа хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Бандихүүгийн
ТҮВШИНЖАРГАЛ**

Маркетинг
хариуцсан захирал

Мобиком корпораци Борлуулалт маркетингийн ажилтан, Таван Богд Трейд ХХК Судалгааны ажилтан, маркетингийн ахлах менежер, Дижитал Агрегатор ХХК Судалгааны ахлах менежерээр тус тус ажиллаж байсан.

2020 оноос Говь ХК-д Маркетинг хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Батсуурийн
БОЛОРМАА**

Дизайн
хөгжүүлэлт
хариуцсан захирал

Дархан Минж ХХК-д Дизайнерээр ажиллаж байсан.

2007 оноос Говь ХК-д Чанар шалгагч, 2008 оноос Дизайнер, загвар зохион бүтээгч, 2016 оноос одоог хүртэл Дизайн хөгжүүлэлт хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Эрдэнэцэцэгийн
ЗОЛЗАЯА**

Үйлдвэр удирдлага
хариуцсан захирал

Нова ноолуур ХХК Үйлдвэрлэлийн менежер, Гүйцэтгэх захирал, MCS Нягтлан бодогч, Гоёо ХХК Төлөвлөлт хангамжийн албаны дарга, Үйлдвэрлэл төлөвлөлтийн хэлтсийн дарга, Говь ХК Сүлжмэлийн үйлдвэрийн даргаар тус тус ажиллаж байсан.

2020 оноос Говь ХК-д Үйлдвэр удирдлага хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Баяраагийн
ЭРДЭНЭ**

Мэдээлэл
технологи
хариуцсан захирал

Зоос банк Техник үйлчилгээний мэргэжилтэн, Төрийн банк Техник үйлчилгээний мэргэжилтэн, Юнител ОУ-ын Роуминг үйлчилгээний мэргэжилтэн, MCS Holding "М" төслийн Мэдээлэл Технологийн Мэргэжилтэн, Бизнесийн ахлах шинжээчээр тус тус ажиллаж байсан.

2020 оноос Говь ХК-д Мэдээлэл Технологи хариуцсан захирлаас ажиллаж байна.



**Цогтбаярын
ЦАСЧИХЭР**

Хуулийн
хэлтсийн дарга

Хэнтий аймгийн Цагдаагийн газарт Мөрдөн байцаагч, Хан-Уул дүүргийн Цагдаагийн газарт Мөрдөн байцаагч, Жаст Ойл ХХК-д Хуулийн зөвлөх, Эм Си Эс ХХК-д Хуульчаар тус тус ажиллаж байсан.

2014 оноос Говь ХК-д Хуулийн зөвлөх, 2018 оноос одоог хүртэл Хуулийн хэлтсийн даргаар ажиллаж байна



**Батпүрэвийн
НАРАНТУЯА**

ТУЗ-ийн нарийн
бичгийн дарга

ШМТДС-д захирлын туслах, Forbes Mongolia сэтгүүлд орчуулагч, Жэт Трак ХХК-д захирлын туслах, ерөнхий менежерээр ажиллаж байсан.

2020 оноос Говь ХК-д ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ НЭР	ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ	
	ДАНГААРАА	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДҮҮД
Д.ХУЛАН	12,247,300 ширхэг (1.57%)	ТАВАН БОГД ТРЕЙД ХХК 50.23%
Ц.БААТАРСАЙХАН	50,000 ширхэг (0.01%)	
О.БОЛОРБАТ	56,768 ширхэг (0.01%)	
НИЙТ		51.82%

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ




“НОГООН ГОВЬ - НОГООН ДЭЛХИЙ ”

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу 2020 оны 06 дугаар сарын 04-ны өдөр Богд хан уулын Хийморийн овооны урд энгэрт 3 га талбайд шилмүүст модоор ойжуулалтын ажил хийж, шинэс 800 ширхэг, хуш 300 ширхгийг тарилаа.

“НЭГДМЭЛ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО”

“Говь” ХК нь Олон улсын удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлэхээр “OBSERVE Consulting” ХХК-с зөвлөх үйлчилгээ авч Эхлүүлэх шат, Төлөвлөлт үе шат, Хэрэгжүүлэлт үе шатыг хэрэгжүүлэн хяналт, сайжруулалтын үе шатанд явж байна. Дэлхийн чиг хандлагад нийцүүлэн үр дүнтэй үйлдвэрлэлийг бий болгон ажилчдын аюулгүй байдал, эрүүл ахуй, ногоон үзэл баримтлал, тогтвортой хөгжлийн үзэл санаанд тулгуурласан компани болох зорилгоор ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандарт, ISO 14001:2015 Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандарт-аар баталгаажуулалтын аудитын хийлгэхээр ажиллаж байна.



GOBI

МОНГОЛЫН С. АТЭМБЭГ

Товь* ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар-17062, Монгол Улс, Ш/Х 36/434

Утас: +976 7013-9977, Факс: +976 7014-3081
И-мэйл: info@gobi.mn